

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 24-ны өдөр

Дугаар

БА-027/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 30 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын 12 давхар, үйлчилгээтэй 71 (далан нэг) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 03-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/09/25 огноо, 0013728 дугаар, БАЗГ2023/714
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: 046-2022-BD
- 2.3. Захиалагч: Чанад Түншлэл ХХК оноосон нэр, 6603831 регистрийн дугаар, Хаяг: Баянзүрх дүүргийн 16-р хороо, 16-р хороолол 61а байр 58 тоот, утас: 99028489

Захиалагч: Боржигин хул адуут овогтой, Гунгаажав Жадамбаа оноосон нэр, УУ57032617 регистрийн дугаартай; Хаяг: Баянзүрх дүүргийн 2-р хороо, 16 хэсэг, цагдаагийн хотхон 11 тоот, утас: 99028489

- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Хүйн Тамир ХХК оноосон нэр, 9011258075 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар; БУ12-1161/19; УБ хот, СХД-ийн 43-р хороо, алтай 7, 743 тоот; утас: 88882195
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:

Хос цамхаг өргөө ХХК, 9011815833 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар; БУ19-727/20; УБ хот, ЧД-ийн 9-р хороо, дэнж 51-5 тоот; утас: 95111445

Мөнх Номгон ХХК, 9011167004 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар; 1367/22; УБ хот, БЗД-ийн 14-р хороо, Консулын, 20-531 утас: 96672949, 99985478

- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Батдах" ХХК, 9011316054 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар; ЗТ16-408/24; УБ хот, СБД-ийн 10-р хороо 04 тоот; утас: 93099298, 98896210

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Чанад Түншлэл ХХК оноосон нэр, 6603831 регистрийн дугаар, Хаяг: Баянзүрх дүүргийн 16-р хороо, 16-р хороолол 61а байр 58 тоот, утас: 99028489

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул барилга байгууламжийг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын 12 давхар, үйлчилгээтэй 71 (далан нэг) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯНАЛТ
Г
Барилга байгуул
орүүл

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 3 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй төвөгшилтэй 12 давхар, үйлчилгээтэй 71 (далан нэг) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 30 дугаар хороо, иргэн Г.Жадамбаа,
Чанад түншлэл ХХК-ийн захиалгатай, ХХК-ийн комисс
12 давхар, үйлчилгээтэй 71 айлын орон сууц

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Чанад Түншлэл ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

(Г.Чинзориг)

Иргэн Г.Жадамбаагийн
итгэмжилсэн төлөөлөл

(Г.Чинзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 30 ДУГААР ХОРОО, ИРГЭН Г.ЖАДАМБАА, ЧАНАД
ТҮНШЛЭЛ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, 12 ДАВХАР, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 71 АЙЛЫН
ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 30 дугаар хороо, иргэн Г.Жадамбаа, Чанад түншлэл ХХК-ийн захиалгатай, 12 давхар, үйлчилгээтэй 71 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхрын 2 тоот өрөөнд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 12:30 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:30 цагт дуусав.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Хуралд:

- | | |
|--|-------------------------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч | Г.Чинзориг |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв
Д.Сүхбат |
| 5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК | |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер | Ц.Наранцацрал
Н.Даваадэмид |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК | |
| 8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Б.Жамбалцанжид |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар /Нийслэлийн Онцгой байдлыг газар / | М.Батсайхан
Б.Оюунжаргал |
| 10. Үндэсний Төв Архив | |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга | Д.Батням |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Б.Ганзориг |
| 13. ОСНААУГазар Зүүн түгээх төвийн засварын хэсгийн ахлах | Ю.Галхүү |
| 14. “Батдах” ХХК - Зураг төсөл зохиогч байгууллага | Б.Баянзул |
| 15. “Хүйн Тамир” ХХК төсөл гүйцэтгэгч байгууллага | Ч.Хатантөмөр |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн -15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 30 дугаар хороо, иргэн Г.Жадамбаа, Чанад түншлэл ХХК-ийн

захиалгатай, 12 давхар, үйлчилгээтэй 71 айлын орон сууцны зориулалттай зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Н. Ёндонсамбуу**

- Бетоны лабораторын шинжилгээ үзүүлэх
- Лифт албан шаардлага биелэлт
- Өөрчлөлтийн зураг хийж батлуулах
- Нийтийн эзэмшлийн коридорт хязгаарлагч хийх
- Дээврийн хар цаасыг засаж янзлах
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж ирүүлэх /14.3, 14.6/
- Усны хаялга доош гүйцэт буулгах

Барилгы стандарт, барилгын аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **З. Очирпүрэв**

- Узельд хаягжуулалт, ус зайлуулах трап
- Айлуудын ариун цэврийн өрөөний холболт гүйцэт угсрах
- Халуун, хүйтэн усны хэрэглээг хэвийн болгох
- Дээвэр дээрх үнэр гаргагч өндөрлөн дулаалах
- Алчуур хатаагчийн төгсгөлд хий авагч угсрах
- Халаалтын босоо шугамуудад дулаан тусгаарлагч хийх
- Дотор сан, салхивч угсарсан ААН-үүдийн тусгай зөвшөөрөл, ил далд ажлын актууд шалгуулах
- Үйлчилгээний өөрчлөлтийн зураг шалгуулах

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн инженер **С.Батням**

- Норм, нормчлалын сангийн төлбөрийг тооцуулан төлөлт хийх

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн инженер **Н.Даваадэмид**

- Гадна холбооны ажлын зураг, акт бичиг баримтыг бүрдүүлэн нөхөж үзүүлэх
- Давхарын самбар дахь кабель шугамын бирк зүүн хаягжуулан, цэгцлэх бэхэлгээг сайжруулах
- Холбооны өрөө болон кабель шугамын тавиурыг хаягжуулах
- Гадна камерыг нэмэлтээр хийж гүйцэтгэх

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Б.Жамбалцанжид**

- Цэвэр усны шугамын холбох цэг техникийн нөхцөлөөс өөрчлөгдсөн тул хүсэлт гаргах өөрчлөх
- Цэвэр, бохир усны шугамын далд ажлын актыг баталгаажуулж шалгуулах



- Холбох цэг /цэвэр/ өөрчлөгдсөн зөвшөөрөл гарвал ажлын зургийг өөрчилж батлуулах
- Гадна цэвэр, бохир шугамын гүйцэтгэлийн зураг хийлгэх
- Нөөцийн санш халдваргүйжүүлэлт хийлгэх, уснаас дээж авч шинжилгээнд өгөх, ашиглах
- Бохир усны худгуудыг стандартын дагуу болгох
- Холбогдох бичиг баримтыг бүрдүүлж гэрээ хийх
- Бохир усны шугамыг ЛДН стар ХХК-ны зөвшилцсөн албан бичгийг шалгуулах
- Гадна цэвэр усны худагт галын гидрант суурилуулах

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчдийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Халаах хэрэгсэлд термстад вилк тавих
- Дотоод тохируулга хийх
- Холигч узельд хаягжуулалт хийх

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техникийн хяналтын инженер **Ц.Наранцацралт**

- ТН 01/03147/24 дагуу 2х800КВА тр-р өргөтгөл хийсэн дэл өртөөний залгах зөвшөөрөл нөхөж үзүүлэх
- Газардуулга, аянгын хүрээний ил далд ажлын акт фото актыг нөхөж бүрдүүлэх
- Давхар дундын ЩИТ болон ерөнхий щитийг хөдөлгөөнгүй бэхлэх, хаяг схем, анхааруулах плакат хадах
- Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, лифт, дулааны узелийн хэрэглээнд тусд нь тоолуур тавих
- Зоорийн давхарын таазаар татсан 0,4КВ-ийн кабелийг зориулалтын тавиураар явуулах
- Техникийн давхарт давтан газардуулгын хүрээ татаж лифт салхивчны тоноглолын холбож өгөх
- Хүчт төхөөрөмжийн угсралтыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулах
- Барилга баригдах үеийн төлбөр тооцоог барагдуулсан баримт нөхөж үзүүлэх. Барилгын үндсэн тэжээлийг лац битүүмжлэхгүйгээр хэрэглэж байна.
- 1-р давхар үйлчилгээний газрыг ТН-д тусгуулах

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасгын дарга **Дэд хурандаа**

М.Батсайхан

- Өөрчлөлтийн зураг төсөл хянуулах
- Шатны хонгилыг тусгаарлах галд тэсвэртэй хаалганд өөрөө хаагч тоноглол хийх
- Техникийн давхарын зураг төслийн дагуу шаталтын бүтээгдэхүүн сорох сэнсийг байрлуулах
- Барилгын дулаалга материалын гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх

ТНАЛТ Ш
ГА.

байгуулан
оруула

- Зэргэлдээх барилгаас гал тусгаарлах хамгаалалтын зай хэмжээ хэдэн метр байгааг хэмжүүлж тайлбар албан бичиг өгөх
- Шаталтын бүтээгдэхүүн сорох, даралттай агаар өгөх системийн автомажуулалт хийх
- ГК гал унтраах дотор усны даралтат цэгийг хэвийн ажилд оруулах
- 1-р давхарын нийтийн эзэмшлийн дотор заслын материалын бичиг баримты үзүүлэх.Автор тайлбар өгөх
- Тагтны дотор засалд зохиогч тайлбар албан бичиг өгөх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Ганзориг**

- Гадна авто зогсоол, явган хүний зам, ногоон байгууламж барилгын хаяг тодорхойгүй байсан тул зургийн дагуу дээрх зүйлүүдийг тодорхой болгох
- 1-р давхарын хэсгийн үйлчилгээний зориулалт уу, орон сууц уу гэдгийг тодорхой болгох, хэрэв үйлчилгээгээр ашиглах бол зориулалтын орц гарц хүртээмжтэй ариун цэврийн өрөөг төлөвлөж гүйцэтгэх
- Лифтний зарлан мэдээлэх төхөөрөмжийг ажилуулах
- В1 давхарын авто зогсоолын тэргэнцэртэй хүн ашиглах боломжгүй байгаа тул оновчтой гарц шийдлтийг олж гүйцэтгэх
- Авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийх хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоолыг хоёроос доошгүй хийх. Бүх зогсоолд дугуйны тээглүүр хийх
- Авто зогсоолоос явган хүний замруу зориулалтын налуу гаргах, явган хүний замыг зурагт заасны дагуу төвшингийн зөрөөгүй 120см –с багагүй өргөнтэй зориулалтын хөтөч хавтан суурилуулсан байх
- Барилгын хаявч явган хүний зам хооронд зурагт заагдсаны дагуу ногоон байгууламжийг хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

ОСНААУГ-ын Зүүн түгээх төвийн засварын хэсгийн ахлах **Ю.Галхүү**

- Цахилгааны гадна кабелийн УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх
- Ус, дулааны холбогдох бүх бичиг баримтыг бүрдүүлж өгөх
- Ус дулааны тооцоог ХҮТ -2 той хийж, бичиг баримт авчирч баталгаажуулах
- ОСНААУГ-с техникийн тодруулгыг нөхөн гаргуулах шаардлагатай ажлыг хийж гүйцэтгүүлэн баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Архивын Ерөнхий газар, Үндэсний Төв Архивын Архивч **Б.Оюунжаргал**

- Архивд баримтаа бүрдүүлэн нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Хувийн хэрэг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй дотоод товъёог хийж бүрдүүлэх
- БУ-ын тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж гарчиглаж эх хувиар өгөх
- Ил далд ажлын акт, гэрчилгээний зургийг ажлын үе шатаар дараалан дотоод товъёог хийж эх хувиар өгөх
- Ажлын зураг болон өөрчлөлтийн зургийг баталгаажуулан зургийн бүрдлийн дагуу эх хувиар өгөх
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат, чанарын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн эх хувиар, дотоод товъёог хийж өгөх

АШИГЛАЛТЫН
АР
ХЭТЭЧИЙН АШИГЛ
КОМИСС

Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Батдах ХХК /зураг төсөл зохиогч/ **Б.Баянзул**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хүйн Тамир ХХК /ерөнхий гүйцэтгэгч/ **Ч.Хатантөмөр**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад авах хүсэлтэй байна.

Иргэн Г.Жадамба, Чанад Түншлэл ХХК-ийн төлөөлөгч **М.Отгонбаатар**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр барилгаа ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт шинэчлэн ирүүлэх
- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгааг албан бичгээр ирүүлэх
- Зохиогчоос барилгын хүчин чадлын тодорхойлолт албан бичиг ирүүлэх
- Батлагдсан гадна талбайн тохижилт ерөнхий төлөвлөгөөний зургийг хуулбарлан ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Баянзүрх дүүргийн 30 дугаар хороо, иргэн Г.Жадамбаа, Чанад түншлэл ХХК-ийн захиалгатай, 12 давхар, үйлчилгээтэй 71 айлын орон сууцны зориулалттай зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тэмдэглэл хөтөлсөн:
Чанад Түншлэл ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Иргэн Г.Жадамбаагийн
итгэмжилсэн төлөөлөл



(А.Мөнгөн)

(Г.Чинзориг)

(Г.Чинзориг)

